



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 8/9

Улаанбаатар хот

Сургалтанд оролцуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2014 оны "Журам батлах тухай" 119 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. Япон улсын "Japanese medical and dental network" эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу АШУҮИС-ийн дэд захирал Б.Амарсайхан, "Их Амгалан" ӨЭМТ-ийн их эмч Б.Энхцэцэг нарыг мэргэжил дээшлүүлэх 14 хоногийн сургалтад 2015 оны 02 сарын 10-наас 02 сарын 25-ны өдрүүдэд суралцуулсугай.
2. Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтанд шаардагдах зардлыг холбогдох зардлын зүйл ангиас тооцон гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Б.Очир/-д зөвшөөрсүгэй.
3. Сургалтын явцын тайланг сургалт эхэлснээс 7 хоногт багтаан бичгээр, суралцаж ирээд төгсөлтийн тайланг 7 хоногийн дотор, үр дүнгийн тайланг 3 дахь сард Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны дарга /Д.Уранчимэг/-д, байгууллагын удирдлагад амаар болон бичгээр ирүүлэхийг ахлагч /Б.Амарсайхан/-д тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аж ахуйн албаны дарга /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ч.БАТ-ЭРДЭНЭ

420062



2016.02.03

Зорилго:

Эрүүл мэндийн хөгжлийн төв, "Япон улсын анагаах, нүүр ам судлалын холбоо"-той 2015 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг дүгнэх, Монгол – Японы бизнесийн чуулга уулзалтанд оролцоход оршино.

Хугацаа:

2016 оны 02 дугаар сарын 11-ээс 15-ны өдрүүдэд

Томилотоор ажиллах улс:

Япон улсын Нагоя хот

Томилотоор ажиллах бүрэлдхүүн:

ЭМСЯ-ны ТЗУГ-ын Хуулийн албаны дарга
ЭМХТ-ийн захирал
АШУҮИС-ын дэд захирал
ЭСҮТ-ийн захирал

Н.Бат-Эрдэнэ
Ч.Бат-Эрдэнэ
Б.Амарсайхан
Г.Уянга

Ажлын чиглэл:

1. Монгол – Японы бизнес чуулга уулзалтанд оролцох
2. Чуулганы явцад Японы эрүүл мэндийн салбарын чиглэлээр танилцаж, туршлага судлах
3. Япон Улсын Анагаах нүүр, ам судлалын холбооны үйл ажиллагаатай танилцах
4. Тус холбоотой хамтран байгуулсан гэрээг дүгнэх, сунгах
5. Монгол Улсын Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны талаар товч мэдээлэл хийх

Ажлын дүн:

- Япон Улсад томилотоор ажилласан тайланг Сайдад танилцуулна.
- ЭМХТ-ийн бие бүрэлдхүүнд гэрээний биелэлтийг мэдээлнэ.
- Япон Улсын "Анагаах, нүүр, ам судлалын холбоо"-той хийсэн гэрээг сунгаж цаашид Монгол Улсын эрүүл мэндийн салбарын эмнэлгийн мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараах сургалт болон резидент эмч нарын солилцооны хөтөлбөрийг бий болгоно.

Удирдамж боловсруулсан:

ЭМХТ-ИЙН ЗАХИРАЛ

Ч.БАТ-ЭРДЭНЭ



ГАДААД ТОМИЛОЛТЫН ТООЦОО

Явах чиглэл:

УЛААНБААТАР-ТОКИО-НАГОЯ-ТОКИО-УЛААНБААТАР

Зочид буудал, зам хоногийн зардал

| Д/д | Томилолтын зардлын төрөл | Доллар | Хүний тоо | Албан томилолтын хугацаа | Нийт зам хоногийн зардал |
|------------|--------------------------|-------------|-----------|--------------------------|--------------------------|
| 1 | Зам хоног | 60 | 4 | 5 | 1,200 |
| 2 | Зочид буудал | 200 | 4 | 5 | 4,000 |
| 3 | Хот доторх унааны зардал | 10 | 4 | 5 | 200 |
| ДҮН | | | | | 5,400 |
| | | \$1=2010=73 | | Төгрөгөөр | 10,858,266 |

Замын зардал

| Д/д | Тээврийн хэрэгсэл /Явах чиглэл/ | Хүний тоо | Замын зардал /2 талдаа/ | Нийт замын зардал |
|------------|--|-----------|-------------------------|-------------------|
| 1 | Онгоц /ULAANBAATAR-TOKYO- ULAANBAATAR/ | 3 | 1,423,400 | 4,270,200 |
| 2 | Онгоц /ULAANBAATAR-TOKYO- ULAANBAATAR/ | 1 | 1,458,800 | 1,458,800 |
| 3 | Визний хураамж | 4 | 51,000 | 204,000 |
| ДҮН | | | | 5,933,000 |

НИЙТ ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ

16,791,266

Хянасан: Ерөнхий нягтлан бодогч

Б.Очир

Боловсруулсан: Гадаад харилцааны мэргэжилтэн

Г.Батцэцэг